МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

## АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙНИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД

# НЭР ДЭВШИГЧ ТАНАА ЗӨВЛӨМЖ

# СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ЦАХИМ СИСТЕМЭЭР НЭР ДЭВШИГЧ БҮРТГҮҮЛЭХ

## СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ “E-ELECTION.MN“-ИЙН ТУХАЙ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.6 дахь хэсэгт заасан Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан цахим систем www.e-election.mn-ийг хөгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал бүх шатны сонгуулийн байгууллагын албан хаагч, нам эвслийн сонгуулийн асуудал эрхэлсэн байгууллагын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч, сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгсэл зэрэг бүртгэлүүдийг цахим системээр зохион байгуулна. Ингэхдээ сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч нь холбогдох бүртгэлийн дагуу системээс гарч буй үнэмлэх гэрчилгээг хэвлэн зохих шатны сонгуулийн хорооны **тэмдэг, гарын үсгээр баталгаажуулна**. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч нь цаасаар эсхүл **цахимаар НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ-ийг илгээх** боломжтой.

Нэр дэвшигч www.e-election.mn системд хэрэглэгчийн эрхээр нэвтэрснээр бүртгэлтэй холбоотой мэдээллийг оруулах, төрийн мэдээлэл солилцооны ХУР системд байгаа лавлагааг www.e-election.mn системээр дамжуулан авах боломжтой бөгөөд ХУР системд ороогүй бусад төрийн байгууллагуудаас авах лавлагаа, баримт бичгийг цахим системд файл хэлбэрээр оруулан материалаа бүрдүүлж **НЭР ДЭВШИХ ХҮСЭЛТЭЭ ИЛГЭЭХ** юм.

Системд хандах эрхийг олгохдоо: Хэрэв нам, эвслээс нэр дэвшигч бол тухайн нам эвслийн сонгуулийн хороодод ирүүлсэн албан бичигт үндэслэн **“Аймаг нийслэлийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан”**-ыг аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн баг бүртгэж, эрх олгоно.

**“Аймаг нийслэлийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан”** нь сум, дүүргийн нэр дэвшигчдэд эрх үүсгэх **“сум дүүргийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан”**-ыг системд бүртгэнэ. Эдгээр **сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтнууд нь** аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр дэвшигчдээ системд бүртгэж нэвтрэх эрх олгоно.

Бие даан нэр дэвшигч бол аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн багаас www.e-election.mn системд нэвтрэх хэрэглэгчийн эрхээ үүсгүүлж авна.

## 1. СИСТЕМД НЭВТРЭХ

Сонгуулийн мэдээллийн цахим системд нэвтрэхдээ дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Нам, эвслийн бүртгэл хариуцсан ажилтан нэр дэвшигчийн Регистрийн дугаар, Овог нэр цахим шуудангийн хаягийн мэдээллийг системд бүртгэснээр Хэрэглэгчийн нэр, Нууц үг нэр дэвшигчийн **бүртгүүлсэн хаягт** илгээгдэнэ.
- Нэр дэвшигч интернэт хөтөч дээр https://www.e-election.mn/login гэсэн системийн хаягийг бичихэд системийн Нүүр хуудас нээгдэнэ.
- Нүүр хуудасны Нэвтрэх хэсэг дэх Хэрэглэгчийн нэр, Нууц үг талбаруудад өөрийн и-мэйл хаягт ирсэн хэрэглэгчийн нэр: «.....» нууц үг: «...» мэдээллийг хуулж оруулаад **Нэвтрэх** товч дарна.




*Зураг 1. Сонгуулийн мэдээллийн цахим системийн нэвтрэх эрх ирүүлсэн цахим шуудан*




*Зураг 2. Системийн нүүр хуудас*

## 2. НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БҮРТГЭХ

Системд нэр дэвшигчийн эрхээр ороход Ерөнхий мэдээлэл хэсэг цонх нээгдэнэ.

Нэр дэвшигчийн Ерөнхий мэдээлэл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ерөнхий мэдээлэл
- Гэр бүлийн байдал
- Боловсролын талаарх мэдээлэл
- Ажлын туршлага
- ШШГГ-ын лавлагаа
- Цагдаагийн лавлагаа
- Татварын лавлагаа
- Шаардлагатай бичиг баримт хавсаргах




*Зураг 3. Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл*

### ҮЙЛДЭЛ 1. Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл бүртгэх

Нэр дэвшигчийн мэдээлэл хэсэгт тухайн иргэний мэдээлэл Нам эвслийн ажилтан бүртгэсэн мэдээлэл харагдана.

- ХУР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар ХУР систем дэх таны хувийн мэдээлэл бөглөгдөнө.
- Зураг, Утасны дугаарын мэдээллийг гараас оруулан **Хадгалах** товч даран дараагийн хэсэг рүү шилжинэ.

### ҮЙЛДЭЛ 2. Гэр бүлийн байдал

- ХУР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар нэр дэвшигчийн гэрлэлтийн мэдээлэл ХУР-аас дуудагдана.
- Бусад гэр бүлийн гишүүдийн мэдээллийг Мөр нэмэх товч дээр даран гараас бөглөнө.

- **Хадгалах** товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Иргэний гэрлэлтийн мэдээлэл дамжуулах сервисээс ирсэн мэдээлэл нь хэсгийн мэдээллийг шалгаж мэдээлэл үнэн зөв бол **Тийм** буруу бол **Үгүй** гэсэн сонгоно.




*Зураг 4. Гэр бүлийн байдал бүртгэх цонх*

## **ҮЙЛДЭЛ 3.** Боловсролын талаарх мэдээлэл бөглөх

- ХУР-с мэдээлэл дуудах товч дарснаар ХУР системд бүртгэлтэй их, дээд сургууль болон бүрэн дунд боловсролын мэдээлэл дуудагдана.
- Элссэн огноо, Дипломын дугаарын мэдээллийг бүртгэнэ.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Боловсролын мэдээлэл нь ирээгүй тохиолдолд Мөр нэмэх товч дээр даран боловсролын мэдээллийг бүртгэнэ үү.




*Зураг 5. Боловсролын талаарх мэдээлэл бүртгэх цонх*

**ҮЙЛДЭЛ 4.** Ажлын туршлага мэдээлэл бүртгэх

- Мөр нэмэх товч дээр дарснаар мэдээлэл оруулах шинэ мөр нэмэгдэнэ.
- Ажил албан тушаалын мэдээлэлээ бүртгэж оруулна.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.




*Зураг 6. Ажил албан тушаалын мэдээллэл бүртгэх цонх*

**ҮЙЛДЭЛ 5.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа

Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа

-https://www.e-election.mn/ цахим системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шүүхийн лавлагаа" хэсгээс ХУР-с мэдээлэл дуудах.

1.Шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй эсэх мэдээлэл дамжуулах сервис дуудагдана.

- Шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй үед ямар нэгэн мэдээлэл харагдахгүй.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.




*Зураг 7. Шүүхийн лавлагаа*

**ҮЙЛДЭЛ 6.** Цагдаагийн лавлагаа

Ял эдэлж байгаа эсэх лавлагааг "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт"-ын дагуу ХУР-с мэдээлэл дуудах, эсхүл маягтаар авч болно. /ЦЕГ-ын Лавлагааны сангийн 70191060, 70191089 дугаар утсаар лавлах боломжтой./

Лавлагааны хуулбарыг https://www.e-election.mn/ системийн нэр дэвшигчийн бүртгэлийн “Шаардлагатай бичиг баримт хавсаргах” хэсэгт оруулна.

- **Системээс ХУР-ын мэдээлэл дуудах** товч дарснаар

1.Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай сервис дуудагдана.

- **Хадгалах** товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бол / Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай мэдээлэл ирсэнгүй. Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай мэдээлэл ирсэнгүй. / мессеж өгнө.




*Зураг 8. Цагдаагийн лавлагаа*

## **ҮЙЛДЭЛ 7.** Татварын лавлагаа

7. Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг ХУР лавлагаанаас гадна байгууллагаас авсан баримт бичгийг файл хавсаргах хэсэгт оруулж болно.

- Системийн ХУР-с мэдээлэл дуудах товчийг дарснаар

1.Иргэний нэр дээр татварын өр шалгах,

2.Иргэний регистрийн дугаараар хувьцаа эзэмшигчийн хувь харах,

3.Байгууллагын нэр дээр өртэй эсэх сервис дуудагдана.

- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй бол / Нэр дэвшигчийн нэр дээр татварын өр байхгүй, Нэр дэвшигчийн хувь эзэмшдэг татварын өртэй хуулийн этгээд байхгүй / мессеж өгнө.

*Зураг 9. Татварын лавлагаа*



**ҮЙЛДЭЛ 8.** Шаардлагатай бичиг баримт хавсаргах

Нэр дэвшихэд шаардлагатай баримт бичгийг Тайлбар хэсэгт баримт бичгийн нэр **Файл хавсаргах** хэсэгт тухайн файлыг хавсаргана. Мөн зарим маягтыг системээс батлагдсан маягтын дагуу татаж ашиглах боломжтой.

Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт

- *Сонгуулийн ерөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл

- *Сонгуулийн ерөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүн, Засгийн газраас байгуулсан төсөл, хөтөлбөрийн нэгж болон хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн бол 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар

- *Шийдвэрийн хуулбарыг https://www.e-election.mn/ системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна.*

Нэр дэвшигчийн намтар */Системд оруулсан хувийн мэдээлэл бүртгэх хэсэг/*

- *Сонгуулийн ерөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт*

Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг /ХОМ мэдүүлсэн маягт/




*Зураг 10. Шаардлагатай бичиг баримт хавсаргах цонх*

## 3. СИСТЕМЭЭС НЭР ДЭВШИХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

- ХУР системээс бүх сервисийг дуудаж хадгалсан, шаардлагатай баримт бичгийг бүрэн хавсаргасан бол тухайн сонгуульд н**эр дэвших тухай хүсэлтээ системээс илгээх боломжтой.**
- Ингэхдээ өөрийн нам, эвсэл болон бие даагчийн төрлийг сонгоно.
- Мөн нэр дэвшигч өөрийн овог, нэрийн мэдээллийг саналын хуудаст хэрхэн хэвлэгдэх тухай мэдээллийг “Нэр дэвшигчийн саналын хуудаст хэвлэгдэх нэр” талбарт бөглөж оруулна.




*Зураг 11. Нэр дэвших мэдээлэл*

- Тогтоол хэсэгт Нам, эвслээс нэр дэвших тогтоолоо хавсарган хүсэлт гаргах товч дээр дарснаар төлөв Хүсэлт гаргасан төлөвт шилжинэ. Хүсэлт гаргасны дараа мэдээлэл засварлаж болохгүй.
- 




*Зураг 12. Нэр дэвших мэдээлэл*




*Зураг 13. Сонгуульд бүртгэх хэсгээр нэр дэвшигчээр баталгаажуулах ажлыг тухайн намын ажилтан хийнэ. Ингэснээр системийн боломжит үйлдэл идэвхжинэ.*




*Зураг 14. Бие даан нэр дэвшигчийг Мэдээллийн технологийн баг хийх бөгөөд Сонгуульд нэр дэвшигчээр бүртгэснээр системийн үйлдлүүд идэвхжинэ.*




*Зураг 15. Нэр дэвшигчийн жагсаалт*




*Зураг 16. “Нэр дэвшигч“-ийг сонгуульд нэр дэвшигчээр бүртгэсний дараа Нэр дэвшигчийн эрхийн тохирогоо хэсэгт СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧИЙН БҮРТГЭЛ хийх хэсэг харагдана.*

**<u>НЭР ДЭВШИГЧ</u>:** *www.e-election.mn цахим системд Менежерээ бүртгэж хэрэглэгчийн эрх үүсгэж өгнө.*

**<u>МЕНЕЖЕР</u>** *нь нэр дэвшигчийн шадар туслах, ухуулагч, ажиглагч, сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн бүртгэлийг системд бүртгэж үнэмлэх, гэрчилгээг хэвлэнэ. Үнэмлэх гэрчилгээг зохих шатны сонгуулийн хороодын даргын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулж сонгуулийн үйл ажиллагаанд ашиглана.*




*Зураг 17. Үнэмлэх, гэрчилгээний жишээ*

# БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ДЭМЖИГЧИЙН БҮРТГЭЛИЙГ ЦАХИМААР ХИЙХ ЗААВАР

## ҮЙЛДЭЛ 1. Дэмжигчийн бүртгэлийн жагсаалт цонхыг дуудах

- Бие даан нэр дэвшигчийн эрхээр болон Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн эрхээр Сонгуулийн мэдээллийн цахим системд нэвтэрч орно.
- **Бие нэр дэвшигчийн дэмжигч бүртгэх** цэсийг дарснаар Бие даан нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонх нээгдэнэ.




*Зураг 18. Бие даан Нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонх*

## ҮЙЛДЭЛ 2. Дэмжигч нэмэх цонх дуудах

- Бие даан Нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонхны **Нэмэх** товч дарснаар Дэмжигч бүртгэх цонх нээгдэнэ.
- Дэмжигчийн мэдээлэл хэсэгт дэмжигчийн Регистрийн дугаарыг оруулахад дэмжигчийн мэдээлэл ХУР-аас дуудагдана.
- Утасны дугаар хэсэгт дэмжигчийн утасны дугаарыг оруулна.
- Хавсралт файл хэсэгт гарын үсэг зурсан файлыг хавсарган Хадгалах товч дээр дарснаар жагсаалтад нэмэгдэнэ.

- Бие даан нэр дэвшигчийн "Нэр дэвшиж буй тойрог"-т Дэмжигч иргэний байнга оршин суугаа хаяг тухайн тойрогт хамаарах шаардлагатай.




*Зураг 19. Дэмжигч бүртгэх цонх*

# БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ДЭМЖИГЧИЙН БҮРТГЭЛ ГАР УТАСНЫ АПП БҮРТГЭХ

## ҮЙЛДЭЛ 1. Дэмжигчийн бүртгэл

- Бие даан нэр дэвшигчийн эрхээр болон Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн эрхээр E-Election аппликэйшнд нэвтэрч орно.
- Дэмжигчийн бүртгэл цэсийг дарснаар **Дэмжигч бүртгэх** цонх нээгдэнэ.
- Дэмжигчийн бүртгэлийг Регистрийн дугаар болон Иргэний үнэмлэхний QR кодийг уншуулан бүртгэх боломжтой.




*Зураг 20. Дэмжигч бүртгэх*

**ҮЙЛДЭЛ 2.** Дэмжигчийн бүртгэл регистрийн дугаараар бүртгэхдээ:

- Дэмжигчийн регистрийн дугаарыг **регистрийн дугаар** хэсэгт оруулан ХУР-аас дуудах товч дээр дарснаар Дэмжигчийн Овог , Нэр бүртгэгдэнэ. ХУР-ын сервис дуудагдах үед иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл, нэр дэвшигчийн тойрогт байгаа эсэхийг шалгана.
- Дэмжигчийн утасны дугаарыг бүртгэснээр утасны дугаарт **Баталгаажуулах код** илгээгдэх ба **Баталгаажуулах код** хэсэгт оруулснаар гарын үсэг зурах цонх нээгдэнэ.
- Дэмжигч гарын үсэгээ зуран **Хадгалах** товч дарснаар дэмжигчийн мэдээлэл амжилттай бүртгэгдэнэ.
    - *Анхааруулга: Иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл Нэр дэвшигчийн тойрогт хамаарахгүй бол “Хаягийн шалгуур хангагүй” мэдэгдэл гарч цааш үргэлжлүүлэх боломжгүй.*







*21. Дэмжигчийн мэдээлэл*  *Зураг 22. Гарын үсэг зурах*

**ҮЙЛДЭЛ 3.** Дэмжигчийн бүртгэл Иргэний үнэмлэхийн QR уншуулах

- Дэмжигчийн бүртгэх цонхны **QR** уншуулах товч дээр даран Иргэний үнэмлэхийн QR кодыг уншуулснаар Дэмжигчийн Овог , Нэр бүртгэгдэнэ. ХУР-ын сервис дуудагдах үед иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл, нэр дэвшигчийн тойрогт байгаа эсэхийг шалгана.

- Дэмжигчийн утасны дугаарыг бүртгэснээр утасны дугаарт Баталгаажуулах код илгээгдэх ба **БАТАЛГААЖУУЛАХ КОД** хэсэгт оруулснаар гарын үсэг зурах цонх нээгдэнэ.
- Дэмжигч гарын үсгээ зуран **Хадгалах** товч дарснаар дэмжигчийн мэдээлэл амжилттай бүртгэгдэнэ.




*Зураг 23. QR уншуулах*




*Зураг 24. Дэмжигчийн бүртгэл*




*Зураг 25. Гарын үсэг зурах*

- Дэмжигчийн мэдээлэл хадгалагдаж, бие даан нэр дэвшигчийн бүртгэлийн жагсаалт нэмэгдэх байдлаар 801 гарын үсгийг цуглуулах боломжтой.




## **ҮЙЛДЭЛ 4.** Сонгогч дэмжигч бүртгэх

Сонгогч гар утасны аппликэйшн ашиглан e-election системд танилт нэвтрэлтийн ДАН-системээр нэвтрэн ороход байнга оршин суугаа хаяг буюу СНЖ-д бүртгэлтэй хаягт тулгуурлан Системд бүртгүүлсэн Бие даан нэр дэвшигчид харагдана. Сонгогч хэдийг ч ДЭМЖИЖ болно.

Play store

App Store

# АЙМАГ НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧИД

| Д/д | МТБагт | Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр | Утасны дугаар |
|---|---|---|---|
| **АРХАНГАЙ АЙМАГ** | | | |
| 1 | Ахлагч | Бямбажавын Булганбаатар | 99339284 |
| 2 | Гишүүн | Гочоогийн Лхагвасүрэн | 99277696 |
| **БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ** | | | |
| 3 | Ахлагч | Саматын Еркебулан | 99617449 |
| 4 | Гишүүн | Хурметхан Маргулан | 99422188 |
| **БАЯНХОНГОР АЙМАГ** | | | |
| 5 | Ахлагч | Бүүвэйн Наранцэцэг | 96505588 |
| 6 | Гишүүн | Ганбатын Алтаншагай | 88661155 |
| **БУЛГАН АЙМАГ** | | | |
| 7 | Ахлагч | Мөнхцэцэг Мөнхбат | 99007595 |
| 8 | Гишүүн | Батбаяр Бумцэнд | 99224345 |
| **ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ** | | | |
| 9 | Ахлагч | Арсланбаатар Доржготов | 90990412 |
| 10 | Гишүүн | Золжаргал Мягмаржав | 95100909 |
| **ГОВЬСҮМБЭР АЙМАГ** | | | |
| 11 | Ахлагч | Даваажавын Мөнх-Эрдэнэ | 99087636 |
| 12 | Гишүүн | Доржсүрэнгийн Энхтуяа | 99656713 |
| **ДАРХАН-УУЛ АЙМАГ** | | | |
| 13 | Ахлагч | Лувсандагвын Баярсайхан | 88307337, 85057337 |
| 14 | Гишүүн | Дашцэрэнгийн Идэрхангай | 99956677, 88001695 |
| **ДОРНОГОВЬ АЙМАГ** | | | |
| 15 | Ахлагч | Цагаанхүү Оюунсайхан | 99013898 |
| 16 | Гишүүн | Чоёнгийн Чулуун | 88771455 |
| **ДОРНОД АЙМАГ** | | | |
| 17 | Ахлагч | Дарьсүрэнгийн Энхбаатар | 99046899 |
| 18 | Гишүүн | Очиржавын Золзаяа | 89066797 |
| **ДУНДГОВЬ АЙМАГ** | | | |
| 19 | Ахлагч | Ганбаатарын Хишигдаваа | 99800657 |
| 20 | Гишүүн | Жаргалсайханы Баярсайхан | 90104440 |
| **ЗАВХАН АЙМАГ** | | | |
| 21 | Ахлагч | Ганзоригийн Бямбаноров | 99043376 |
| 22 | Гишүүн | Дондовцэрэнгийн Мөнхтөр | 95237979 |

| | | | |
|---|---|---|---|
| **ОРХОН АЙМАГ** | | | |
| 23 | Ахлагч | Дуламсүрэнгийн Ядамсүрэн | 99559085 |
| 24 | Гишүүн | Нямдаваагийн Болортуяа | 95888844 |
| **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ** | | | |
| 25 | Гишүүн | Маналгомбын Багмадцэрэн | 88052966 |
| 26 | Гишүүн | Бямба-очирын Даржаа | 91109647 |
| **ӨМНӨГОВЬ АЙМАГ** | | | |
| 27 | Ахлагч | Цэнгэлийн Золбоо | 88114655 |
| 28 | Гишүүн | Баямбасайхан Нандинчулуун | 95001066 |
| **СҮХБААТАР АЙМАГ** | | | |
| 29 | Ахлагч | Чулуунбаатарын Батболд | 96510404 |
| 30 | Гишүүн | Лутжаргалын Батбилэг | 88515155 |
| **СЭЛЭНГЭ АЙМАГ** | | | |
| 31 | Ахлагч | Чимбээгийн Гандүүрэн | 99093600 |
| 32 | Гишүүн | Жанчивренчингийн Баттөр | 96499596 |
| **ТӨВ АЙМАГ** | | | |
| 33 | Ахлагч | Цогбаярын Хосбаяр | 99948808 |
| 34 | Гишүүн | Батмөнхийн Доржнямбуу | 99284582 |
| **УВС АЙМАГ** | | | |
| 35 | Ахлагч | Цэгмэдийн Цэдэвсүрэн | 89998638 |
| 36 | Гишүүн | Пүрэвийн Гантулга | 88452412 |
| **ХОВД АЙМАГ** | | | |
| 37 | Ахлагч | Төмөрийн Бат-Өлзий | 99907914 |
| 38 | Гишүүн | Эрдэнэчимэгийн Цэгмэд | 99435532 |
| **ХӨВСГӨЛ АЙМАГ** | | | |
| 39 | Ахлагч | Гантөмөр Энхбаяр | 99992895 |
| 40 | Гишүүн | Цэрэндоржийн Чагнаадорж | 99387994 |
| **ХЭНТИЙ АЙМАГ** | | | |
| 41 | Ахлагч | Жамцдоржын Энхбат | 99155488 |
| 42 | Гишүүн | Норовсүрэнгийн Үнэнбат | 99048755 |
| **НИЙСЛЭЛ** | | | |
| 43 | Гишүүн | Балдандаваагийн Бямбанасан | 88001051 |
| 44 | Гишүүн | Улаандалай Даваацэрэн | 99465901 |
| **БАГАНУУР ДҮҮРЭГ** | | | |
| 45 | Ахлагч | Алтанцэцэгийн Ганзориг | 91075006 |
| 46 | Гишүүн | Баасанжавын Алтангэрэл | 99168098 |

| | | | |
|---|---|---|---|
| **БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ** | | | |
| 47 | Ахлагч | Нямжавын Батболд | 99865240 |
| 48 | Гишүүн | Амарсанаагийн Отгонжаргал | 94646442 |
| **БАЯНГОЛ ДҮҮРЭГ** | | | |
| 49 | Ахлагч | Баярсайханы Алтантуяа | 99971601 |
| 50 | Гишүүн | Содномдоржийн Жавхлан | 91102727 |
| **БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ** | | | |
| 51 | Ахлагч | Гомбын Гансүрэн | 88115287 |
| 52 | Гишүүн | Нансалмаагийн Лхаажав | 88036150 |
| **НАЛАЙХ ДҮҮРЭГ** | | | |
| 53 | Ахлагч | Дамжингийн Бат-Эрдэнэ | 88408983 |
| 54 | Гишүүн | Баяржаргалын Хүслэн | 88086457 |
| **СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ** | | | |
| 55 | Ахлагч | Сүрэнчулууны Туулмаа | 91074400 |
| 56 | Гишүүн | Болд Ганболд | 99926022 |
| **СҮХБААТАР ДҮҮРЭГ** | | | |
| 57 | Ахлагч | Төмөрбаатарын Төрболд | 88001543 |
| 58 | Гишүүн | Цэнд-Аюуш Бэлгүдэй | 89112279 |
| **ХАН-УУЛ ДҮҮРЭГ** | | | |
| 59 | Ахлагч | Пилжээгийн Тамир | 88887282 |
| 60 | Гишүүн | Адилбишийн Амартөвшин | 99441206 |
| **ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ** | | | |
| 61 | Ахлагч | Чулуунбаатарын Бадамцэрэн | 91179229 |
| 62 | Гишүүн | Ганболдын Батболд | 90102899 |